



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/401

Улаанбаатар хот

**Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэгийн  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 24,151,702.96 (хорин дөрвөн сая нэг зуун тавин нэгэн мянга долоон зуун хоёр төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэг (Б.Түмэнжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 18 нэр төрлийн 18,367,963.96 (арван найман сая гурван зуун жаран долоон мянга есөн зуун жаран гурван төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 7 нэр төрлийн 5,783,739 (таван сая долоон зуун наян гурван мянга долоон зуун гучин ес) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 60,000 (жаран мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 18,000 (арван найман мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэг (Б.Түмэнжаргал)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001101





Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/401 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн 138 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдлэг үнэ	Эвдрэл гэмтэл	Байгууллагын үнийн санал	НӨАТ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХК-ын шийдвэр
1	Өсгөгч	7	ш	1	100,000	100,000	100,000	-	эвдэрхий	устгах	5,000	5,000
2	Өсгөгч dj	13	ш	1	650,000	650,000	650,000	-	эвдэрхий	устгах	5,000	5,000
3	Пийшин /зуух/	38	ш	2	50,000	100,000	100,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
4	Буузны жигнүүр	12	ш	1	528,000	528,000	528,000	-	эвдэрхий	устгах	10,000	10,000
5	Пийшин /цахилгаан/	12	ш	1	1,760,000	1,760,000	1,760,000	-	эвдэрхий	устгах	10,000	10,000
6	Төмс цэвэрлэгч	12	ш	1	984,000	984,000	984,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
7	Ус буцалгагч 08	12	ш	1	600,000	600,000	600,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
8	Тоос сорогч /хар/	10	ш	1	180,000	180,000	180,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
9	Телефон аппарат	8	ш	1	10,000	10,000	10,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
10	Зурагт	13	ш	1	120,000	120,000	120,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
11	Машин /угаалгын-2-беко/	6	ш	1	2,200,000	2,200,000	2,200,000	-	эвдэрхий	устгах	10,000	10,000
12	Машин /угаалгын/	6	ш	1	316,900	316,900	316,900	-	эвдэрхий	устгах	10,000	10,000
13	Машин /хатаагч-беко/	6	ш	1	2,200,000	2,200,000	2,200,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
	<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>					<b>9,748,900</b>	<b>9,748,900</b>	-			50,000	50,000
14	Хүүхдийн ширээ /45500/	12	ш	60	45,500	2,730,000	2,730,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
15	Хүүхдийн сандал /19800/	12	ш	280	19,800	5,544,000	5,544,000	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
16	Ширээ урт	15	ш	1	309,320	309,320	309,320	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
17	Хувцасны шүүгээ	37	ш	22	104,560.18	2,300,323.96	2,300,323.96	-	эвдэрхий	устгах	устгах	устгах
18	Гэр ком	38	ш	1	228,839	228,839	228,839	-	эвдэрхий	устгах	10,000	10,000

